

МУИС-ИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛД Ю. ЦЭДЭНБАЛ ХОЛБОГОДОХ НЬ.

Ц.Жамбалсүрэн

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, ТүүХийн Тэнхим

Өгүүллийн товч утга: МУИС-ийн Түүхийг нарийн судлах, тус Сургуулийн хөгжилд гаралттай үүрэг гүйцэтгэсэн хүмүүсийн үйлсийг судлах нь Их Сургуулийн түүхчдийн үүрэг мөн. МУИС-ийг байгуулахад Монголын нам, төрийн зүтгэлтэн агсан Ю.Цэдэнбалын үүргийг нээн харуулах зорилт тавив.

Түлхүүр уг: Монгол Улсын Их Сургууль, Ю.Цэдэнбал, Соёл боловсрол.

МУИС-ийн үүсэл хөгжлийн түүхийн анхны баримт бичиг бол 1940 оны III, IV сард хуралдсан МАХН-ын X их хуралтай холбоотой. Манайд урьд нь их, дээд сургуулиар бэлтгэгдсэн сэхээтэн цөөн болсон, ялангуяа эрх баригч нам, төр, засгийн удирдлагад ийм хүн бараг байгаагүй болохоор дээд боловсролын тухай сэтгэлгээ хөгжөөгүй байсан билээ. Их хурлын үндсэн илтгэлүүдэд дээд сургуулийн тухай дурьдаагүй нь үүний нотолгоо юм. Харин Монголын шинэ үеийн сэхээтний төлөөлөгчид их хуралд сонгогдон оролцсон нь дээд сургууль байгуулах шийдвэр гараад төлөөсөн байж болох юм.

1940 оны III сарын 22-ны их хурлын шийдвэрээр тогтоол, баримт бичгийн комиссийн бүрэлдэхүүнд Ю.Цэдэнбал нарын шинэ үеийнхэн орсон байдаг. IV сарын 5-нд батлагдсан их хурлын тогтоолд: "Ойрын жилийн дотор дээд сургуулийг байгуулах бэлтгэлийг хангах"¹ заалт орсон нь МУИС-ийг байгуулах анхны түүхэн шийдвэр мөний зэрэгцээгээр дээрх тогтоол нь намын удирдлагад дөнгөж гарч ирж байсан Ю.Цэдэнбалын биечлэн оролцож боловсруулсан анхны баримт бичиг байсан нь сонирхол татаж байна.

1940 онд МАХН-ын удирдлагад гарч ирсэн Ю.Цэдэнбал эх орныхоо соёл боловсролыг хөгжүүлэхийг нэн чухал зорилт гэж үзэж байв. 1940 оны V сард хуралдсан МХЗЭ-ийн ТХ-ны IV бүгд хурал дээр хэлэхдээ: "НТХ, СНЗ-өөс сум бүрт сургууль байгуулах тогтоол гаргаж, энэ жил зун ба өвлийн нийлсэн бүгд 217 сургууль байгуулахаар тогтоон явуулж байна. Ямар ч улс нэг жилд өдий чинээ сургууль байгуулсан түүх үгүй. Бид үүнийг онцгойгоор үнэлэн үзэх хэрэгтэй. Энэ жил 50 мянган хүнийг бичиг үсэгт сургах төлөвлөгөөтэй байна. соёлын фронт бол ажлын өргөн талбар мөн"² гээд энэ ажлыг зохион байгуулж, ер нь боловсролын салбарт эргэлтийн үе эхэлсэн Юм.

1940 оны XII сарын 6-нд Сайд нарын Зөвлөл "Улаанбаатар хотноо улсын университет байгуулах тухай" 45 дугаар тогтоол гаргажээ³. (**УИС-ийн архив. 1942, хавтас 1, № 7.**)

Гадаадад 10 жил сурсан, монголын дээд боловсролтой анхны эдийн засагч Ю. Цэдэнбал МУИС-ийг байгуулж бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан билээ. НТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга болсон Ю.Цэдэнбал соёл боловсролын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх хүнийг судалж эхэлсэн бөгөөд түүний биечлэн дэвшүүлж гаргаж ирсэн анхны хүн нь Т.Машлай байлаа. Эрхүү, Улаан-Үдийн Рабфак, монгол курсад сурч байх үеийн танил, боловсролын байгууллагад олон жил ажилласан зохих туршлагатай, бас ч гэж нутаг усных нь хүн байжээ. 1940 оны V сард Гэгээрлийн яамны боловсролын хэлтсийн дарга байхад нь Ю.Цэдэнбал түүнийг өөрийнхөө туслахаар татаж ажиллуулжээ.

Тэр хавар Улсын VIII их хурал хуралдаж, хоёрдахь Үндсэн хуулийг баталж, Улсын Бага Хурлын гишүүнд 75 хүнийг сонгожээ. Т.Машлай гуйд дурссанаар:

¹ УИС-ийн архив. 1942. хавтас -, №7

"Их хурлын төгсгөл ойртоож байлаа. Нэг өдөр Цэдэнбал дарга : "Чи өнөөдөр УИХ-д очиж суугаарай" гэв. Би "даргаа, миний ажил их байна, эмхлэх цэгцлэх зүйл олон бий" гэхэд Цэдэнбал : "за чи түүнийгээ орой шене хийчихнэ биз. Харин чи заавал очоорой" гэлээ" гэжээ. "Их хуралд очоод сутал хурлын төлөөлөгчид УБХ-г сонгох асуудал хэлэлцэж эхлэв. УИХ-ын төлөөлөгчидөөс гадна хүн гэвэл Бумцэнд гуай, Машлай хоёр л байв. Хурлын явцад Бумцэнд Машлай нарын нэрийг дуудаж, Улсын Бага Хурлын гишүүнээр сонгох саналыг Ю.Цэдэнбал дарга гаргав. Төлөөлөгчид Т.Машлайн түүх намтарыг сонсож хэлэлцээд УБХ-ын гишүүнээр сонголоо... Улсын энэ ХХI бага хурлаар Т.Машлайг Ардын гэгээрүүлэх яамны сайдаар томилжээ"⁴.

Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл Монгол Улсын Их Сургуулийг байгуулах түүхэн шийдвэрээ хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүргийг Гэгээрлийн сайд Т.Машлайд даалгажээ. Манай ахмад үеийн гайхамшигт хүмүүсийн нэг болох Т.Машлай 1944 онд Б.Ширэндэв МУИС-ийн ректор болох хүртэл Их сургуулийн амьдралд идэвхтэй оролцож, боловсрол, соёл, гэгээрлийг хөгжүүлэх улсын хэмжээний их ажлын хажуугаар энэ үүргийг нэр төртэй биелүүлж, МУИС-ийг нээх бэлтгэлийг хангах, сургалт хүмүүжлийн ажлыг эмхлэн цэгцлэх, ялангуяа хичээлийн байртай болох практик ажлыг хөөцөлдөн хэрэгжүүлж, МУИС-ийг байгуулахад хүндэтгэй гавъяа байгуулсан юм.

1942 оны Х сарын 5-нд МУИС-ийг нээх ёслол Лениний нэрэмжит клубт болжээ. Баярын цуглаан дээр "Дээд сургуульд суралцагчдын суралцах зорилгын тухай" гол илтгэлийг НТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал тавьж, Маршал Чойбалсангийн хүндэт сануулгыг уншин сонсож, Шинжлэх ухааны хүрээлэнгийн баярын бичгийн танилцуулжээ.⁵

МУИС-ийн нээлтийн баярын хурал дээр тавьсан гол илтгэлдээ Ю.Цэдэнбал : "...Сүүлийн жилүүдэд мэргэжлийн боловсон хүчиний хэрэгцээ хурцаар мэдрэгдэж байна. Хэрэв урьд нь бидний хэрэгцээг дунд сургуулиас авч буй боловсон хүчин үндсэндээ хангаж байсан бол хүн амын соёл, улс төрийн түвшин өсөхийн хэрээр жил ирэх тутам дээд боловсролтой мэргэжилтэнүүд улам ихээр шаардагдаж байна... Манай оронд дээд сургууль нээж байгаа нь өөрийн эх орондоо дээд мэргэжилтэй үндэсний боловсон хүчин бэлтгэх бололцоог бидэнд анх удаа олгож байна. Өөрийн оронд дээд сургуулийг зохион байгуулахдаа монголын залуучуудад бидний олгох мэдлэг нь манай бүтээн байгуулалтын ерөнхий зорилттой нягт холбоотой байхад бид зорьж, зорьсондоо хүрэх ёстой. Манай анхны дээд сургуулийн оюутан болж буй залуус шинэ амьдралд хөл тавьж байна. Нээгдэж буй дээд сургуульд элсэн суралцагч бүр оюутан болох нь ихээхэн нэр төрийн хэрэг гэдгийг ойлгох ёстой. Түүнчлэн өөртэйгээ маш шаргуу хичээнгүй ажилласан нөхцөлд л дээд боловсролыг жинхэнэ ёсоор олж авна гэдгийг оюутан нэг бүр ойлгох хэрэгтэй. Дээд сургуульд суралцах нь ихээхэн бэрхшээлтэй тулгарна гэсэн үг, тийм учраас оюутан бүр дээд боловсрол олж авах замд тохиолдох саад бэрхшээлийг даван туулахад өөрт байгаа бүх хүчээ дайчилдаг байх ёстой. Дээд сургуулийн оюутан, багш нарын өмнө оюутан нэг бүрийг олж авсан мэдлэгээ ашиглаж чаддаг, мэдлэг оюунаа тасралтгүй боловсронгуй болгодог бүтээлч ажилтан болгон бэлтгэх зорилт тавихыг би хүсч байна"⁶ гэж шинэ тутам байгуулагдаж буй Их сургуулийн зорилтыг тодорхойлсон байна.

Нам төрийн ахмад зүтгэлтэн, Гавьяат хуульч С.Жалан-аажав: "1941 онд НТХ-ны шийдвэрээр Нам, улсын төв сургууль гэж байсныг Намын шинэ хүчиний дээд сургууль болгон өөрчилж, би энэ сургуульд элссэн юм. Бүх элсэгчдийг НТХ-ны УТТ-ны хурлаар хэлэлцэн баталдаг журamtай байлаа. Энэ нь боловсон

⁴ Ж.Болдбаатар. Төрийн зүтгэлтэн, түмний багш. УБ., 2005. т-45

⁵ Г.Загд. МУИС-ийн түүхээс. УБ., 1968. т-12

⁶ "Нэн. (Правда) 1942, 6 октября., №239 (136)

хүчин бэлтгэх асуудалд онцгой анхаарал тавьж байсантай холбоотой байв. УТТ-ны хуралд Х.Чойбалсан Маршал хувцастай, бусад нь энгийн хувцастай байсан. Мэргэжилтэн бэлтгэхтэй холбогдсон ярианы үед Ю.Цэдэнбал: "юны өмнө хүмүүсийг эрүүлжүүлэх, малын өвчнөес ангижрах хэрэгтэй байна. Үндэсний мэргэжилтэн бэлтгэх УИС байгуулах, тэнд эмч бэлтгэх явдал их чухал байна" гэхэд Маршал Х.Чойбалсан: "Чи юу хэлэв? гэж лавлахад Ю.Цэдэнбал давтан дээрх санаагаа хэлэв. Х.Чойбалсан "энэ их зөв зүйтэй санал байна. Би Ивановтой ярья. Зөвлөлт засгийн газарт санал хүсэлт тавьяя. Чи тогтоолын төсөл бичээдэх, би явахаасаа өмнө гарын үсэг зурчихая" гэж шууд шийдвэрлэн ярилцаж байсан. Энэ дагуу удалгүй УИС-ийн тухай, тэнд эмч бэлтгэх тухай СНЗ-ийн шийдвэр гарч, дараа жил нь УИС байгуулагдсан. Ер нь үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх ажилд 1940 оноос үндсэн эргэлт гарсан юм шүү. Энэ нь Ю.Цэдэнбалын гэгээрлийн шинэтгэгч бодлоготой холбоотой байсан"

МУИС нээгдсэний дараахан Ю.Цэдэнбалын удирдаж байсан НТХ-ны тэргүүлэгчдийн 1942 оны XII сарын 17-ны өдрийн хурлаар "МУИС-ийн ажлын тухай" авч хэлэлцээд малын эмчийн ба зоотехникийн 2 салбар бүхий мал эмнэлгийн факультетийг өргөтгөн байгуулах, дээд сургуульд багшлах боловсон хүчин бэлтгэхийн тулд онцсайн сурлагатай, тэргүүний оюутнуудыг сонгон авч тусгай программаар хичээллүүлэх шийдвэр гаргаж хэрэгжүүлжээ. 1943 оны V сарын 20-нд Намын Төв Хорооны Тэргүүлэгчид, СНЗ-ийн хамтарсан хурлаас "МУИС-ийн хичээлийн төв байр барьж яаралтай дуусгах тухай" тогтоол гаргасанд НТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал, ерөнхий сайд Х.Чойбалсан нар гарын үсэг зуржээ. 1944 оны I сарын 4-ний 12 цагт МУИС-ийн хичээлийн байрны суурь тавих ёслол болж ерөнхий сайд Х.Чойбалсан, намын дарга Ю.Цэдэнбал, ардын гэгээрлийн яамны сайд Т.Машлай нарын удирдах хүмүүс оролцон, эдүгээгийн төв байрны баруун хойд өнцгийн суурин доор монгол заншилаар, цай, хадаг, дурсгалын бичиг байрлуулж, барилгын суурин анхны чулууг тавих ёслол үйлджээ. Барилгын ажлыг түргэтгэх холбогдох заалтуудыг тэд өгч, ажлын явцтай танилцаж байлаа. Барилгын ажил хугацаандаа дуусч ашиглалтад орсон юм.

МУИС-ийн байр суурь, биеэ даасан байдал, нэр төрийг өндөржүүлэх нь сургалт хүмүүжлийн цаашдын ажилд сайнаар нөлөөлнө гэж Монголын удирдагчид үзэж байна. Энэ зорилгоор Ю.Цэдэнбалын шийдвэрээр 1944 оны IX сарын 1-нээс Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Ширэндэвийг МУИС-ийн ректороор хавсруулан ажиллуулах болсон юм. МУИС-ийн анхны ректор Б.Ширэндэв, Ю.Цэдэнбал нарын харилцаа ойр дотно байжээ. Б.Ширэндэв дурсахдаа: "Цэдэнбал 1938 онд, би 1941 онд дээд сургуулиа төгссөн юм. Цэдэнбал төгсөж ирээд дээгүүр албан тушаалд орчихсон байлаа. Би төгсөж ирээд багшийн сургуульд багшилж байтал Цэдэнбал намайг татаж засгийн газрын референтээр ажилд томиллоо. Мөн тэндээс НТХ-д шилжин ажиллаж байлаа" гэжээ.

Ю.Цэдэнбал тун удалгүй Ширэндэвийг НТХ-ны нарийн бичгийн даргаар дэвшүүлж, зөвлөлтийн элчин, НТХ-ны орос зөвлөхтэй хэл амаа олоогүйн улмаас чөлөөлж, гэгээрлийн сайдаар ажиллуулаад, 1944 онд дахин НТХ-ны нарийн бичгийн даргаар дэвшүүлж, УТТ-ны орлогч гишүүн болгожээ. Ю.Цэдэнбал 1952 онд ерөнхий сайд болмогц, Б.Ширэндэвийг ерөнхий сайдын нэгдүгээр орлогч болгож, 1954 онд УТТ-ны жинхэнэ гишүүн болгожээ. Доктор хамгаалаад ирсний дараа Ширэндэв гуайн дурссанаар: "Цэдэнбал намайг удирах ажилд томилно гэсэн би түүнээс татгалзан, эрдэм шинжилгээний ажил хийе гэж хүссэн. Тэр ёсоор шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга, МУИС-ийн

⁷ Ю.Цэдэнбалын Академийн архив.ф-1, хн-6, т-384

ректороор томилсон. 1961 онд ШУА байгуулагдахад ерөнхийлөгчөөр сонгогдож, МУИС-ийн ректороос чөлөөлөгдсөн" гэжээ. Ю.Цэдэнбал нэрт эрдэмтэн Ширэндэвийг өндөр үнэлж, ямагт дэмжиж, МУИС-ийн ректороор ажиллуулах шийдвэр хоёр удаа гаргасан бөгөөд Б.Ширэндэв: "Тэр надаас өмнө төгсөж ирээд ажиллаж эхэлсэн болохоор мэдлэг чадвараар надаас илүү тул надад зааж сургаж өгдөг байлаа... Цэдэнбал үг дуу цөөнтэй, төлөв даруу, ном их уншдаг, нягт нямбай, ажлын эцсийг үздэг махруу, томоотой хүн байж билээ" гэжээ.

1946 оны МУИС-ийн анхны төгсөлтийн улсын шалгалтын комиссд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Т.Маштай нар ажиллаж, шалгалт авч байлаа. Мөн оны VI сард анхны төгсөлтийн ёслолын хурал болж Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Г.Бумцэнд нар оролцон баяр хүргэж, төгсөгчидөд зөвлөлгөө сургамж өгчээ.

МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1947 оны II сарын 1-ний V хурлын Ю.Цэдэнбалын гарын үсэгтэй тогтоолоор МУИС-ийг сайд нарын зөвлөлийн шууд мэдэлд шилжүүлж, ректорыг яамны сайдын, проректорыг орлогч сайдын адил эрхтэй болгосон нь МУИС-ийн цаашдын бэхжилтэд нэн чухал ач тустай болжээ. МУИС-тай холбогдсон ямар ч асуудал хурдан түргэн шийдвэрлэгдэх болов. Энэ тогтоолоор МУИС-д марксизм-ленинизмийн ба философиийн, улс төрийн эдийн засгийн ухааны, түүхийн тэнхимтэйгээр Нийгмийн Ухааны Факультет байгуулагдсан юм. Энэ үед УТТ-ны тогтоолоор МУИС-ийн дэргэдэх намын байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх заалт өгч, НТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний шийдвэрээр МУИС-д намын зохион байгуулагчийн орон тоог буй болгожээ. Түүний үүрэг нь МУИС-ийг хөгжүүлэхэд намын дэмжлэг туслалцааг зохион байгуулах, оюутныг соёлтой, эх оронч, иргэний үзэл хүмүүжилтэй болгоход тус дэм үзүүлэх явдал байв.

1947 оны XII сард хуралдсан МАХН-ын XI их хурал МУИС байгуулагдсаныг манай орны соёлын том ололт гэж дүгнэв. Их хурал дээр Ю.Цэдэнбал тавьсан илтгэлдээ МУИС-ийн хөгжлийн асуудлыг тусгайлан анхаарч "Таван жилд их сургуульд суралцагчдын тоог 2,2 дахин нэмэгдүүлэх, төгсөгчдөөсөө аспирантурт үлдээн суралцуулж үндэсний багш, шинжлэх ухааны ажилтан бэлтгэх" зорилтыг дэвшүүлжээ.

Ю.Цэдэнбал 1952 оны V сарын 26-нд ерөнхий сайд болонгуутаа засгийн газрын шийдвэр гаргаж 1952 оны IX сарын 1-нд МУИС-д Эдийн Засгийн Факультет нээв. 1959 оны намраас ЭЗФ нь Эдийн Засгийн Дээд Сургууль болон өргөжсен юм.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1957 оны VIII сарын 10-ны 347 дугаар тогтоолоор "УИС-ийн зарим факультет, салбарууд, суралцах хугацаа, багш нарын хичээл заах цагийн хэмжээг өөрчлөх тухай" шийдвэр гаргаж, 1960 оны VIII сард СнЗ-ийн 319/229 тоот тогтоолоор барилга инженерийн салбарыг өргөтгөж, Инженерийн факультет болгожээ. МАХН-ын ТХ, СнЗ 1962 оны V сарын 19-нд "УИС-ын ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" 196/266 тоот тусгай тогтоол гаргаж "одоо үед улс ардын аж ахуй, соёлын салбарт ажиллах онолын зохих бэлтгэлтэй, социалист байгуулалтын практиктай танил мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах эрхэм үүрэг их сургуулийн өмнө тавигдаж байна" гэж УИС-ийн шинэ зорилтыг тодорхойлжээ. УИС-ийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож УИС-д ФМФ, ПТФ, БУФ, НУФ, ХБФ ба утга зохиолын оройн дээд сургууль, барилга инженерийн оройн салбар ажиллах болов. Их сургуулийн амьдралыг шинэ шатанд гаргасан энэ тогтоолд нам, засгийн тэргүүн Ю.Цэдэнбал мөн л гарын үсэг зурж, биөлэлтийг нь зохион байгуулжээ.

1962 Онд СнЗ-ийн шийдвэрээр дээд, тусгай дунд боловсролын хороо байгуулагдах хүртэлх үед МУИС-ийн амьдралтай холбогдсон бүх асуудалд нам, засгийн удирдагч Ю.Цэдэнбал биечлэн оролцож, МУИС-ийг хөгжүүлэх үйлсэд

өөрийн хувь нэмрээ оруулж байсан билээ. МУИС-ийн хүндэт проф, гавьяат хуульч, доктор С.Жалан-Аажав: "Аугаа их мэдлэгтэй түүнтэй ажиллахад их сайхан байсан. Хүний хэлж ярьсанд анхааралтай хандана. Бусдын санааг хүндэтгэнэ. Оросоор бичихээд л үзүүлнэ. Жалан-Аажав минь одоо бидэнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль ёсыг чандлан хэрэгжүүлэх ажил ус агаар мэт чухал байна. Чиний мэргэжлийн наймхан хүнтэй. Тэгэхээр бид энэ ажилд хүч тавих ёстой гэж нэг өдөр хэлэв. Тэгэхээр нь би "Тэгвэл МУИС-д хуулийн анти нээе" гэдэг санал гаргаж, Цэдэнбал уг ажлыг надад даалгаж, мэргэжлийн хуульч эх орондоо бэлтгэж эхлээд 40 жилийг ардаа хийжээ. Ю.Цэдэнбал ингэж хууль, эрх зүйн шинэчлэлийг тэртээ жилүүдэд хийлгэж байлаа"⁹ *(Ю.Ц:Хүм.Дурсамж.І,Т.134)

МУИС-ийг багшлах боловсон хүчин, удирдлагаар хангахад Ю.Цэдэнбал онцгой анхаарч МУИС-ийн ректороор дэлхийд алдартай шилдэг эрдэмтэд: нэрт түүхч, төр, нийгмийн зүтгэлтэн Б.Ширэндэв, нэрт биологич эрдэмтэн, зохиолч, төр, нийгмийн зүтгэлтэн Д.Цэвэгмид, нэрт физикч эрдэмтэн, академич, профессор Н.Содном, нэрт эдийн засагч, профессор, төр, нийгмийн зүтгэлтэн Ж.Батмөнх, нэрт биологич эрдэмтэн, академич О.Шагдарсүрэн нарыг ажиллуулж байсан нь МУИС-ийг хөгжүүлэхэд гаралтай уүрэг гүйцэтгэжээ.

Ю.Цэдэнбал МУИС-ийг бэхжүүлэхэд цаг ямагт анхаарал тавьж, Монголын эрдэм мэдлэгийн гол уурхай болсон энэ сургуульд тун элэгсгээр хандаж өөрөөс шалтгаалах бүхнээр тусалж байжээ. МУИС-ийн ректороор 17 жил ажилласан, академич Н.Содномын эрдэм номын алтан шар замд нь Ю.Цэдэнбал тусалсан ажээ. Н.Содном дурсахдаа: "1949 оны зун манай нам, засгийн төлөөлөгчид Москвад ирэхэд Аюушжав бид хоёр метрополь зочид буудалд буусан Цэдэнбал даргатай очиж уулзлаа. Бид хийж гүйцэтгэсэн ажлаа танилцуулаад Москвагийн УИС-ийн аспирантурт орж суралцах хүсэлтээ тавилаа. Цэдэнбал дарга тэр дор нь бидний саналыг сайшаан дэмжиж, цаашид суралцахыг зөвшөөрч, элчин яаманд үүрэг өгнө гэлээ. Ингээд л маргааш, нөгөөдөр нь элчиний хүн бид хоёрыг дагуулж, зөвлөлтийн дээд боловсролын яаманд очоод Москвагийн УИС-ийн аспирантаар томиллууллаа" гэжээ. Академич Н.Содном "Монгол Улсын Университет" номынхоо "Буянтай учрал" бүлэгт Ю.Цэдэнбалтай уулзаж саналаа хэлсний ачаар "Улсын 60 жилийн ойгоор урьд үзэгдээгүй олон багш нар тэр, засгийн шагнал авч, дараа нь түүхэнд үзэгдээгүй олон орон сууцыг МУИС-д бэлэглэсэн юмаа. МУИС-д тус бүр 300 хүн суух оюутны байр 3-ыг, багш нарын 48 айлын орон сууц 2-ыг улсаас бариулж өглөө. Цэдэнбал дарга их сургуулиа мартсангүй¹⁰ гэж тэмдэглэн бичжээ. Нэрт эрдэмтнийг Ю.Цэдэнбал дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролын улсын хорооны даргаар томилж байсан бөгөөд хожим нь Н.Содном ШУА-ийн ерөнхийлөгчөөр ажилласан билээ.

Нэрт биологч эрдэмтэн, авьяаслаг сурган хүмүүжүүлэгч, зохиолч Д.Цэвэгмид нь Ю.Цэдэнбалын хүндэтгэл хүлээсэн хүн байсан бөгөөд МУИС – ийг хөгжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн юм. НҮБ-д монгол улсаа элсүүлэх үйлсийг 1946 онд Ю.Цэдэнбал эхэлж, Д.Цэвэгмид нь 1961 онд монголын далбааг НҮБ-д мандуулж байлаа. МУИС-иас төрөн гарсан сурган хүмүүжүүлэх их туршлагатай, шинжлэх ухаан, соёл, боловсролын салбарт өндөр нэр хүндтэй энэ хүнийг Ю.Цэдэнбал сайд нарын зөвлөлийн орлогч даргаар дэвшүүлэн ажиллаж байлаа.

Д.Цэвэгмид ректорын дараа Ю.Цэдэнбал нэрт эдийн засагч, профессор Ж.Батмөнхийг МУИС-ийн ректороор томилсон бөгөөд их сургуулийг удирдаж байсныг харгалзан, түүний эдийн засгийн онол шинжлэх ухааны мэдлэг чадварыг үнэлж, Сайд нарын Зөвлөлийн даргын өндөр сэнтийд гаргасан билээ. 1984 оны үйл явдлын дараа нам, төрийн тэргүүн болсон Ж.Батмөнх гуай хожим нь дурсахдаа: "Ю.Цэдэнбал бол мэдлэг боловсролын суурь сайтай, их хөдөлмөрч, маш тэвчээртэй, зан харилцааны хувьд зелдэг, хүнийг өөртөө татах

увидастай, өөрийн гэсэн маш хатуу дэг журамтай нэгэн байсан гэж би боддог. Энэ нь ялангуяа албан үүргээ гүйцэтгэж байгаа үед нь бүр ч тод илэрнэ. Харин жирийн цагт бол хошин шог ярийн зэргээр оюуны алжаалаа тайлах дуртай. Ярж хөөрөх санаа бодлоо илэрхийлэхдээ хэлэх үгээ маш цэгнэж, туйлын болгоомжтой хандана. Орос хэлийг гарамгай эзэмшсэн¹¹ гэж хүндэтгэлтэйгээр бичиж үлдээжээ.

МУИС-ийн түүхэнд нэрээ үлдээсэн нэрт сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн, гавьяат багш О.Шагдарсүрэнг түшмэдүүд эхнэрийнх нь гаралтай холбож, гадаадад аспирантурт явуулахгүй байжээ. Ирээдүйн ректор Ю.Цэдэнбалд хандан хүсэлтээ илэрхийлж, шинжлэх ухаанд амжилт гаргаж чадахыг нь таньж мэдсэн Ю.Цэдэнбал шийдвэр өгч О.Шагдарсүрэнг дэмжин гадаадад аспирантурт илгээж байжээ. Академич О.Шагдарсүрэн дурсахдаа: "1982 онд би МУИС-ийн ректор болох үеэр Бал дарга бид хоёр шинжлэх ухаан, боловсролын хэд хэдэн асуудлын талаар ярилцсан билээ. Тэгэхэд Цэдэнбал дарга: их сургуулийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд их анхаар. Ялангуяа чи тэр орос хэл дээр хичээл заадаг улсынхаа чадварыг дээшлүүлээрэй. Дэлхийн шинжлэх ухааны чухал хэл шүү гэж захиж байлаа. Тэрээр: МУИС ч өргөжих ёстой. Эрдмийн энэ өргөөнд ардын хүүхэд улам олноор сурах хэрэгтэй. Их сургуулийг бэхжүүлэх санаа төлөвлөгөөг чинь би дэмжинэ гэв. Ю.Цэдэнбал МУИС-ийг санаачлагч, зохион байгуулагчийн нэг, их сургуулийн нээлтийн хурал дээр их сургуулийн зорилтыг тодорхойлсон гол илтгэлийг тавьж байсан хүний хувьд их сургуулиараа бахархаж, цаг ямагт санаа тавьж, тулгарсан асуудлыг шууд шийдэж өгдөг хүн байж билээ. Цэдэнбал дарга ер нь ШУА, МУИС-ийн эрдэмтдийг байнга урьж уулздаг, үүндээ их дуртай хүн байсан. Ялангуяа Б.Ширэндэв, Д.Цэвэгmid, Ж.Батмэнх, Н.Содном, Хурметбек бидэнд их дотно хүндэтгэлтэй ханддаг байсан юм. Заримдаа албан яриа, уулзалтад биш, ерийн ярилцаж зөвлөлдөхийн тулд ч биднийг гэнэт урьчихдаг сонин зантай энгийн хүн байв..."¹² гэжээ.

МУИС-ийн ректороор ажиллаж байсан, гавьяат багш Д.Дорж их сургуулийн амьдралд Ю.Цэдэнбалын гүйцэтгэсэн үүргийг тодорхойлж: "Монголын эгэл жирийн малчин ардын хүү би миний ард түмний бахархал болсон МУИС-ийн ректораар ажиллаж байсныгаа боловсрол, их сургууль, шинжлэх ухааныг хөгжүүлэх Ю.Цэдэнбал гуайн их бодлогын ач үр гэж боддог. Чухам энэ үед монголын дээд боловсрол хөгжсөн. Энэ хү МУИС-ийг санаачлан байгуулагчийн нэг, олон жил их сургуулийн амьдралыг удирдаж, хамгийн шилдэг боловсон хүчинээ их сургуульд томилж, их сургуулийн материалыг базыг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан болохын хувьд МУИС-ийн түүхийн алтан хуудсыг бичилцсэн хүн гэж зүй ёсоор тооцогдох ёстой. Энэ тухай МУИС-ийн хамт олон, оюутан залуус, төгсөгчид гүн хүндэтгэлтэйгээр санаж дурсах нь их сургуулийнхаа түүхийн өмнө бидний хүлээх ариун үүрэг мөн"¹³ гэжээ.

Ийнхүү МУИС нам, төр, засгийн байнгын анхаарал халамжид ямагт байж, эх орон, ард түмнийхээ итгэл найдварыг нэр төртэй биелүүлж Монголын соёл, шинжлэх ухаан, боловсролын нэгэн томоохон оргил болж чадсан билээ. Энэ үйлсэд Ю.Цэдэнбал томоохон хувь нэмэр оруулжээ.

Ю.Цэдэнбал нам, улсын боловсон хүчин бэлтгэх тогтолцоог ч өөрчлөн шинэчилсэн бөгөөд энэ тухай НДС-ийн тэнхимиийн эрхлэгч байсан, ахмад дайчин, доктор, проф.Б.Дашзвэг: "1941 онд намын төв сургуулийг намын шинэ хүчний дээд сургууль болгон өөрчлөх ажлыг санаачлагч нь Ю.Цэдэнбал байсан. 1941 оны нээлт, 1943 оны анхны төгсөлтийн хурал дээр үг хэлж, улмаар цаашдын зорилтыг зааж байжээ. Ю.Цэдэнбал тус сургуулийн Улс төр эдийн засгийн ухааны тэнхимиийн эрхлэгч, улсын шалгалтын комиссын даргаар олон жил ажилласан сурган хүмүүжүүлэгч хүн байсныг тэр болгон мэддэггүй. Мөн

багш нарын бүрэлдэхүүнийг чанаржуулахад онцгой анхаарч олон шилдэг багш нарыг томилж байлаа. Захирлаар Ч.Сүрэнжав, багшаар Д.Төмөр-Очир, Б.Ширэндэв, С.Жалан-Аажав, Ц.Цэдэнжав, Ч.Лодойдамба, Э.Шагдар, Ц.Намсрай нарын зэрэг өндөр мэдлэгтэй багш нарыг томилон ажиллуулж байв. Х.Чойбалсангаар ч ардын хувьсгалыг хэрхэн удирдан зохион байгуулсан тухай цуврал лекц урьж уншуулж байсан юм. Ю.Цэдэнбал политэкономын лекц уншихад эхний туслахаар нь "Үнэн" сонины эрхлэгч Ц.Намсрай, дараа нь У.Камбар нар ажиллаж байсан. Ю.Цэдэнбал лекц уншихад Намсрай томъёонуудыг самбар дээр бичээд байдагсан. Ю.Цэдэнбал даргын лекц уншиж буй кино журнал ч буй. Энэ талын түүхэн баримтууд тус сургуулийн архивт хангалттай байгаа¹⁴ тухай тэмдэглэжээ.

НТХ, Цэргийн улс төрийн газрын шийдвэрээр 1943 онд цэргийн Ерөнхий сургуулийг өргөтгөн Д.Сүхбаатарын нэрэмжит офицерын сургууль болгож, цэргийн дарга нарыг бэлтгэх болов. Ийнхүү боловсон хүчин бэлтгэх системийг үндсээр нь шинэчлэн өөрчлөх бодлогыг Ю.Цэдэнбал тууштай хэрэгжүүлсэн юм.

Abstract: This article observes the role of Yu.Tsedenbal in the establishment of the Mongolian State University, development of Mongolia's education, culture and science.

¹⁴ Ф.Цэдэнбал: Хүмүүсийн дурсамж. I боть, УБ., 2002, т-97